



**УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**



ᠤᠪᠰ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ ᠳᠡᠷᠭᠡᠳᠡᠬᠡ
ᠰᠠᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠡᠰ

NSO.MN



ᠳᠡᠯᠬᠢᠶᠢᠨ
ᠰᠠᠲᠢᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ
ᠥᠳᠦᠷ

**ДЭЛХИЙН
СТАТИСТИКИЙН
ӨДӨР**

20.10.2020

НАЙДВАРТАЙ
ТОО МЭДЭЭЛЛЭЭР
ЭХ ДЭЛХИЙГЭЭ
ХОЛБОЁ

1212.MN

**УВС АЙМГИЙН НИЙГЭМ,
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

2020/09



УЛААНГОМ ХОТ 2020 ОН

**УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

**УВС АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН
ЗАСГИЙН БАЙДАЛ**

**2020 он
9 сар**

***НАЙДВАРТАЙ ТООН МЭДЭЭЛЛЭЭР ЭХ ДЭЛХИЙГЭЭ
ХОЛБОЁ***

Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх, дэлхий нийтийг хамарсан цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахад албан ёсны статистикийн ач холбогдол, үүрэг нь урьд өмнө хэзээ ч байгаагүйгээр чухал болж байгаа энэ үед Дэлхийн статистикийн өдрийг тэмдэглэх гэж байна. Дэлхийн статистикийн өдрийг НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 2010 оны 64/267 тоот тогтоолын дагуу анх 2010 оны 10 сарын 20-ны өдөр тэмдэглэж, 130 гаруй гишүүн улс, 40 орчим олон улсын болон бүс нутгийн байгууллага, аж ахуйн нэгжүүд идэвхтэй оролцож, олон төрлийн үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан байна.

НҮБ-ын Ерөнхий Ассемблей 2015 оны 6-р сард 69/282 тоот тогтоол гаргаж, Дэлхийн статистикийн өдрийг 5 жил тутамд 10-р сарын 20-нд тэмдэглэж байхаар шийдвэрлэв. Дэлхийн статистикийн хоёр дахь өдрийг 2015 оны аравдугаар сарын 20-нд 130 гаруй улс орон тэмдэглэжээ. Өгөгдөл улам их чухал үүрэг гүйцэтгэдэг болсон энэ эринд бидний гаргаж буй тогтвортой эх үүсвэр бүхий найдвартай өгөгдөл нь ертөнцийг холбох үндэс суурь болдог.

НҮБ-ын Статистикийн комиссын 51-р хуралдаанаар "Дэлхийн статистикийн өдөр-2020"-ыг 10 сарын 20 нд тэмдэглэхээр зарласан байна.

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН ХААНААС АВАХ ВЭ?

WWW.1212.MN СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Статистик 

Мэдээ, мэдээлэл 

Номын сан 

Мэдлэгээ шалгах
ТОГЛООМ 

Валютын ханш 



©2017


аппликейнаас


СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛЭЭ АВААРАЙ

Data lab | тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network

 www.facebook.com/StatisticMongolia/


 www.twitter.com/statistic_mn

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn

ГАРЧИГ

| | |
|--|----|
| Ерөнхий тэмдэглэл | 4 |
| Статистик мэдээллийн өнгө, таних тэмдэг..... | 5 |
| Хэрэглэгчдэд лавлагаа | 7 |
| Товч танилцуулга..... | 8 |
| Үндсэн үзүүлэлт | 38 |
| IV.Хөдөлмөр..... | 40 |
| VI. Нийгмийн даатгал, халамж..... | 44 |
| VIII. Эрүүл мэнд | 46 |
| X. Соёл | 49 |
| XI. Байгаль орчин | 49 |
| XII. Гэмт хэрэг..... | 50 |
| XIV.Мөнгө, зээл..... | 52 |
| XV.Төрийн санхүү | 52 |
| XVI.Гадаад худалдаа..... | 54 |
| XVII. Үнэ | 55 |
| XVIII. Хөдөө аж ахуй | 58 |
| XIX. Аж үйлдвэр..... | 64 |
| XX. Тээвэр | 66 |

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР :

1. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III , IV, V..... г.м)
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.
2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :
... мэдээлэл байхгүй
0.0 маш бага тоо
- гүйцэтгэл байхгүй
Д - дахин
3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

4. Та цахим хэлбэрээр үзэж буй тохиолдолд танилцуулга дээрх QR кодыг ашиглан дэлгэрэнгүй мэдээллийг uvs.nso.mn сайтаас татан авч ашиглаж болно.



Үндэсний статистикийн хорооны даргын
2013 оны 12 сарын 06 өдрийн 113-т тоот
тушаалын гуравдугаар хавсралт

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН ӨНГӨ, ТАНИХ ТЭМДЭГ

| Д/д | Таних тэмдэг | Мэдээллийн нэр | Өнгө | Вэбийн өнгө R/G/B | Хэвлэлийн өнгө S/M/Y/K |
|-----|---|---|---------------|-------------------|------------------------|
| 1 |  | Засаг захиргаа, нутаг дэвсгэр | Шар | 255/212/0 | 0/15/100/0 |
| 2 |  | Сонгууль | Шар | 255/212/0 | 0/15/100/0 |
| 3 |  | Хүн ам | Цайвар ногоон | 128/195/66 | 55/0/100/0 |
| 4 |  | Хөдөлмөр | Цайвар ногоон | 128/195/66 | 55/0/100/0 |
| 5 |  | Хүн амын амьжиргаа | Цайвар ногоон | 128/195/66 | 55/0/100/0 |
| 6 |  | Нийгмийн даатгал, халамж | Улаан | 217/31/61 | 10/100/80/0 |
| 7 |  | Боловсрол, шинжлэх ухаан | Шар | 255/212/0 | 0/15/100/0 |
| 8 |  | Эрүүл мэнд | Цайвар ногоон | 128/195/66 | 55/0/100/0 |
| 9 |  | Хүний хөгжил | Улаан | 217/31/61 | 10/100/80/0 |
| 10 |  | Соёл, аялал жуулчлал, биеийн тамир, спорт | Шар | 255/212/0 | 0/15/100/0 |
| 11 |  | Байгаль орчин | Ногоон | 14/178/76 | 80/0/100/0 |
| 12 |  | Гэмт хэрэг | Улаан | 217/31/61 | 10/100/80/0 |

| Д/д | Таних тэмдэг | Мэдээллийн нэр | Өнгө | Вэб-д R/G/B | Хэвлэлд S/M/Y/K |
|-----|--------------|-------------------------------------|------------|-------------|-----------------|
| 13 | | Үндэсний тооцоо | Хөх | 23/71/158 | 100/85/0/0 |
| 14 | | Мөнгө, банк, даатгал | Хөх | 23/71/158 | 100/85/0/0 |
| 15 | | Төрийн санхүү | Хөх | 23/71/158 | 100/85/0/0 |
| 16 | | Төлбөрийн тэнцэл, гадаад худалдаа | Хөх | 23/71/158 | 100/85/0/0 |
| 17 | | Үнэ | Хөх | 23/71/158 | 100/85/0/0 |
| 18 | | Хөдөө аж ахуй | Улбар шар | 248/165/26 | 0/40/100/0 |
| 19 | | Аж үйлдвэр | Цэнхэр | 117/190/223 | 50/10/0/0 |
| 20 | | Тээвэр, харилцаа, холбоо | Цэнхэр | 117/190/223 | 50/10/0/0 |
| 21 | | Худалдаа, үйлчилгээ | Цэнхэр | 117/190/223 | 50/10/0/0 |
| 22 | | Барилга, орон сууц, нийтийн аж ахуй | Цэнхэр | 117/190/223 | 50/10/0/0 |
| 23 | | Бизнес регистр | Цэнхэр | 117/190/223 | 50/10/0/0 |
| 24 | | Дэлхийн улс орнуудын хөгжил | Хөх цэнхэр | 64/133/197 | 75/40/0/0 |

Хэрэглэгчдэд зориулсан лавлагаа:

Аймгийн Статистикийн хэлтсээс гаргаж буй дараахь мэдээлэл, танилцуулга, тооллого, түүвэр судалгааны үр дүнг uvs.nso.mn хаягаар орох болон аймгийн Засаг даргын Тамгын газрын II байранд байрлуулсан электрон самбарыг ашиглан үзэж, холбогдох мэдээллээ авч болно. Үүнд :

- Аймгийн нийгэм эдийн засгийн байдлын танилцуулгууд
- Ажиллах хүчний үр дүнгийн танилцуулга
- Өрхийн нийгэм эдийн засгийн түүвэр судалгааны үр дүн
- 2010 оны Хүн ам орон сууцны тооллогын үр дүн, сум, багаар
- 2020 оны Хүн ам орон сууцны тооллогын үр дүн, сум, багаар
- Аж ахуйн нэгжийн тооллогын үр дүн, аймгуудаар, сумдаар, 2010 он
- Судалгааны үр дүнгүүд
- 2013-2019 оны ХАА-н салбарын танилцуулга,
- 2013 -2019 оны Хүн ам, өрхийн төлөв байдал сэдэвт танилцуулга
- 2013-2019 оны Аймгийн үйлдвэр, үйлчилгээний салбарын танилцуулга
- 2013-2017 оны Хүн амын ажил эрхлэлтийн танилцуулга
- Аймгийн ДНБ үйлдвэрлэлт-2014 онд
- Хүн амын хүрээлэн буй орчны танилцуулга 2018-2019
- 2016-2020 оны сар бүрийн танилцуулгууд
- Статистикийн эмхэтгэлүүд
- Статистикийн өврийн дэвтрүүд
- Инфографикууд

Улс, аймгийн мэдээлэл авах хаяг: uvs.nso.mn www.uvs.gov.mn

Мэдээллийн сангаас авах бол: www.1212.mn

Увс аймгийн Статистикийн хэлтсийн ажилтнуудтай харилцах хаяг :

uvs@nso.mn/ албаны хаяг /

Утас: 70452322, 70453316, 99906004, 89610610, 99760175, 94000570






III. ХҮН АМ


3.1 Хүн ам

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 9 сард 1540 эх амаржиж, 1543 хүүхэд амьд төрж, нас баралт 325 болж, өмнөх оны мөн үеэс амаржсан эх 110 (7.7%) – аар, төрсөн хүүхэд 99 (6.9%) – өөр өсч, нас баралт 12 (3.6%) - оор буурчээ. 1000 хүнд ноогдох төрөлт 18.5, нас баралт 3.9, цэвэр өсөлт 14.6 болов. Өмнөх оны мөн үеэс 1000 хүнд ноогдох төрөлт 1.2 промиллээр өсч, нас баралт 0.2 промиллээр буурчээ.

Зураг 3.1 Төрсөн хүүхдийн тоо, онуудаар



Зураг 3.2 1000 хүнд ноогдох төрөлт, нас баралт, цэвэр өсөлт, жил бүрийн эхний 9 сарын байдлаар



1000 хүн амд ноогдох төрөлтийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 0.8 промиллээр өсч, нас баралтын тоо өмнөх 3 жилийн дунджаас 0.2 промиллээр буурсан байна.

Гэрийн төрөлт 7 гарчээ. Нийт нас баралтын 15.4 хувийг эмнэлгийн нас баралт эзэлж өмнөх оны мөн үеэс 0.6 пунктээр өссөн байна.

Ойлголт тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлтийг төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.




IV. ХӨДӨЛМӨР

4.1 Шинэ ажлын байр болон бүртгэлтэй ажилгүйчүүд

Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн 9 сард ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 729 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 15 (2.1 %) хүнээр өссөн байна. Аймгийн хэмжээнд 383 эмэгтэй ажил идэвхитэй эрж байгаа нь ажилгүйчүүдийн 52.5 хувийг эзэлж байна.

2020 оны 9 сард бүртгүүлсэн, ажил идэвхитэй эрж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 36 (4.7 %) ажилгүйчүүдээр буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 14 (1.9 %) хөгжлийн бэрхшээлтэй иргэд байна.

Зураг 4.1 Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо



Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт энэ онд 2119 ажилгүй иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан ажилгүйчүүдээс 431 иргэн ажилд зуучлагдан орж, 2406 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагджээ.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 15-24 насны 25.8 хувь, 25-34 насны 48.4 хувь, 35-44 насны 15.5 хувь, 45-54 насны 9.6 хувь, 55-59 насны 0.6 хувь, 60 дээш насны 0.1 хувь ажилгүйчүүд байна. Ажилгүйчүүдийн 29.3 хувь нь дээд, 18.4 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 39.9 хувь нь бүрэн ба бүрэн бус дунд боловсролтой, 12.6 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс эзэлж байна.

Зураг 4.2 Бүртгэлтэй ажилгүйчүүд боловсролын түвшингээр




Энэ оны эхний 9 сард 1212 ажлын байрны захиалга ирсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 227 (23.0%) –оор өссөн байна.

Зураг 4.3 Ажлын байрны захиалга, ажилд орсон хүний тоо



Ажлын байрны захиалгын 2.1 хувийг боловсролын салбарын, 5.5 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн, 12.9 хувийг ХАА-н, 79.5 хувийг бусад салбарын захиалга эзэлж байна.

Зураг 4.4 Ажлын байрны захиалга дүнд эзлэх хувиар, салбарын ангиллаар




Ажлын байрны захиалгын дийлэнх буюу 20.8 хувь нь мэргэжилтний, 30.7 хувь нь үйлдвэрлэл барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний захиалга байлаа.




Зураг 4.5 Бүртгэлтэй ажилгүйчүүдээс ажилд орсон иргэд, салбарын ангиллаар

Ажилд орсон иргэдийн 25.7 хувь нь төрийн удирдлагын салбарт, 15.2 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 13.8 хувь нь ХАА-н салбарт, 5.2 хувь нь боловсролын салбарт, 40.1 хувь нь бусад салбарт ажилд орсон байна.



Ажилд орсон иргэдийн 50.1 хувь нь 25-34 насны залуучууд, 22.7 хувь нь 35-44 насныхан, 24.6 хувь нь 45-59 насныхан байна.

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн 49.5 хувь нь байнгын ажлын байранд, 20.6 хувь нь түр ажлын байранд, 29.9 хувь нь улирлын ажлын байранд тус тус ажилд оржээ.



Ойлголт тодорхойлолт:

Ажил хайгч иргэн: Ажилгүй эсхүлажилтай боловч ажлын нөхцлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.


Бүртгэлтэй ажилгүй иргэн: Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.



VI НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ


Нийгмийн даатгалын сангийн орлого энэ оны эхний 9 сард 15583.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 321.4 (2.1%) сая төгрөгөөр, сангийн зарлага 48321.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5324.3 (12.4%) сая төгрөгөөр тус тус өслөө.

Зураг 6.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага эхний 9 сард, сая төгрөг




Эрүүл мэндийн даатгалын сангаас бусад нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг бүх сумууд 32.5 – 72.2 хувиар давуулан биелүүлсэн байна. Нийгмийн даатгалын сан 1064.6 сая төгрөгийн авлагатай байна. Нийт авлагын 23.3 хувийг төсөвт байгууллагын өглөг эзэлж байна.

Зураг 6.2 Нийгмийн даатгалын сангийн орлого, сангуудаар, сая төгрөг




Сангуудаар авч үзвэл өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн орлого 887.8 (9.1%), тэтгэмжийн даатгалын сангийн орлого 53.8 (4.9%), ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 3.9 (1.7%) сая төгрөгөөр тус тус өсч, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 559.8 (16.7%), ҮОМШӨ –ний даатгалын сангийн орлого 64.3 (7.5%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Зураг 6.3 Нийгмийн даатгалын сангийн зарлага, сангуудаар, сая төгрөг




Өмнөх оны мөн үеэс тэтгэврийн даатгалын сангийн зарлага 6333.7 (18.2%), тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 292.0 (18.4%), ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 374.5 (2.9 дахин), үйлдвэрийн осол, мэргэжлээс шатгаалах өвчний даатгалын сангийн зарлага 9.3 (14.0%) сая төгрөгөөр тус тус өсч, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 1685.2 (56.2%) сая төгрөгөөр буурсан байна.

Зураг 6.4 Нийгмийн даатгалын сангийн зарлагын бүтэц, хувиар



Нийгмийн халамжийн сангаас энэ оны эхний 9 сард 36.1 мянган хүнд 10440.2 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеэс олгосон тэтгэвэр тэтгэмж 240.5 (2.4%) сая төгрөгөөр өссөн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэрт энэ оны эхний 9 сард 1.6 мянган хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 61 (3.6%) хүнээр буурч, олгосон тэтгэвэр 1166.4 (47.4%) сая төгрөгөөр өссөн байна.

Зураг 6.5 Халамжийн сангийн зарцуулалт, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, сая төгрөг



Энэ оны эхний 9 сард цалинтай ээж хөтөлбөрт 3902 хүн хамрагдаж 202.8 сая төгрөг, хүнс тэжээлийн тусламжинд 8840 хүн хамрагдаж, 1488.4 сая төгрөгийн тусламж авчээ. Асрамжийн газар нийт 16 хүн асруулж байгаа бөгөөд 11 нь эмэгтэй байна. Асрамжийн үйл ажиллагаанд нийт 153.5 сая төгрөгийг зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 22.9 (17.5%) сая төгрөгөөр өсч, асруулагчийн тоо өнгөрсөн оноос 1 хүнээр буурсан байна.

Ойлголт тодорхойлолт:

Даатгуулагч: Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан,


нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг ойлгоно.




VIII. ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдэл эхний 9 сард 21, 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 24 гарч, 1000 амьд төрөлтөнд нялхсын эндэгдэл 13.6, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 15.6 ноогдож байна.

Зураг 8.1 1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдэл, сараар



Зураг 8.2 1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын ба 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл



1000 амьд төрөлтөнд ноогдох нялхсын эндэгдэл Хяргас , Сагил суманд 250.0, Баруунтуруун суманд 76.9, Зүүнговь суманд 71.4, Өндөрхангай суманд 47.6, Өмнөговь суманд 22.2 ноогдож аймгийн дунджаас 8.6 – 236.4 промиллээр өндөр, Улаангом суманд 10.6 ноогдож аймгийн дунджаас 3.0 промиллээр бага байна.


Зураг 8.3 1000 амьд төрөлтөд ноогдох нялхсын эндэгдлийн түвшин, сумаар

Зураг 8.4 1000 амьд төрөлтөд ноогдох 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, сумаар




Эхний 9 сарын байдлаар осол гэмтлийн улмаас 32 хүн нас барж, өвчлөгчдийн тоо 601 болсон нь өмнөх оны мөн үеэс өвчлөгчдийн тоо 130 (27.6%)-аар өсч, нас баралтын тоо 11 (25.6%)-ээр буурсан байна.

Зураг 8.5 Осол гэмтлийн өвчлөл, нас баралтын тоо




Хорт хавдрын өвчлөл 119 гарч өмнөх оны мөн үеэс 19 (13.8%) -өөр буурч, нас баралт 125 гарсан нь өмнөх оны мөн үеэс 14 (12.6%) - өөр өсчээ.

Зураг 8.6 Хорт хавдрын өвчлөл, нас баралтын тоо




Энэ оны эхний 9 сард халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 430 болж өнгөрсөн оны мөн үеэс 41 (10.5%) хүнээр буурч, өмнөх 3 жилийн мөн үеийн дунджаас 5.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 8.7 Халдварт өвчний гаралт, тоогоор




Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнийг хувиар авч үзвэл нийт халдварт өвчний 73.7 хувийг БЗХӨ, сүрьеэ 7.4, гепатит 2.8, салхинцэцэг 4.9, цусан суулга 4.4, бусад халдварт өвчин 6.8 хувийг тус тус эзэлж байна.

Зураг 8.8 Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд, хувиар, 2019 I-IX сар




Зураг 8.9 Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд, хувиар, 2020 I-IX сар




10000 хүн тутмаас 52 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд Улаангом 94 байгаа нь аймгийн дунджаас 42.2 процентимилээр өндөр, бусад сумдад аймгийн дунджаас 5.0 – 43.2 процентимилээр бага байна. Харин Сагил суманд халдварт өвчний тохиолдол гараагүй байна.

Зураг 8.10 10000 хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд



Зураг 8.11 10000 хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд



Амбулаториор 287.0 мянган хүнд үзлэг хийгдэж, 14.9 мянган хүн хэвтэн эмчлэгдсэн байна.

Ойлголт тодорхойлолт:

Амьд төрөлт: Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байгааг (хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүй) хамруулна.

Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн жилд 0-28 хоногтой эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд ногдох): Тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тооцно.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшин: Тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны дундаж хүн амын тоонд харьцуулж тооцно.


Эндсэн эх: Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэнийг хамруулна.



Х.Соёл


Аймгийн хөгжимт драмын театр нийт 8 үзвэр үйлчилгээ зохион байгуулж 1.1 мянган хүнд үйлчилжээ. Үүнээс 2 урлагийн тоглолтоор 0.7 мянган хүнд үйлчилсэн байна.

Зураг 10.1 Драммын театрын тоглолт, үзэгчдийн тоо




Орон нутгийг судлах музей 2.0 мянган хүнд үйлчилж 812.0 мянган төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс үзэгчид 2 дахин, орлого нь 2.8 дахин буурсан байна. Энэ оны эхний 3 дугаар улиралд нийт 5 үзмэрээр урын сангаа баяжуулсан байна.

Зураг 10.2 Музейн үзэгчид ба орлого



Төв номын сан 11.5 мянган уншигчдад 15.3 мянган номоор үйлчилсэн нь өмнөх оны мөн үеэс уншуулсан ном 54.5 хувиар, уншигчдын тоо 2.8 дахин тус тус буурсан байна.

Зураг 10.3 Номын сангийн уншигчид, уншуулсан ном



/ * 2018 оноос хойш нийт уншигчдын тоо/



XI. Байгаль орчин

Энэ оны 9 дүгээр сард агаарын температур дунджаар Давст, Завхан, Зүүнговь, Наранбулаг, Тэс сумдад 11-с дээш дулаан, хөрсний гадаргын дундаж температур Бөхмөрөн, Наранбулаг, Завхан, Зүүнговь, Сагил суманд хамгийн дулаан +16-с дээш градус байжээ. Салхины хамгийн их хурд Малчин, Ховд, Баруунтуруун суманд 21 - 24 м/сек хүрсэн бөгөөд 10 м/сек-ээс их салхитай өдөр Өмнөговь, Өндөрхангайд 19 өдөр байв. Баруунтуруун суманд 35.8 мм хур тунадас орсон нь бусдаас илүү байна. Өнгөрсөн оны мөн үеэс тоос 0.029 мг/м^3 , азотын давхар исэл 0.005 мг/м^3 –аар их байсан хэдий ч хүлцэх агууламжаас давсан тохиолдол гараагүй байна.

9.2 Аюулт үзэгдэл, ослын тохиолдол

2020 оны 9 дүгээр сард эрэн хайх, аврах ажиллагааны тохиолдол 1, объектын гал түймэр 17 тохиолдол гарсан байна. Эдгээр гамшиг осол гал түймрийн улмаас иргэдийн хувийн өмчинд 46.9 сая төгрөгийн хохирол учирч, гамшиг осол, гал түймрийн аюулаас иргэдийн 55.0 сая төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалжээ.

Ойлголт тодорхойлолт:

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга болон, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан олноор хорогдох, эд хөрөнгө хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохиролучрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.




XII. ГЭМТ ХЭРЭГ, ШҮҮХ

12.1 Гэмт хэргийн статистик

Энэ оны эхний 9 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 147 болж өнгөрсөн оны мөн үеэс 107 (42.1%)-аар буурчээ. Гэмт хэргийн улмаас 68 хүн гэмтэж, 152 иргэн хохирсон байна.


Зураг 12.1 Гэмт хэргийн гаралт, жил бүрийн эхний сарын байдлаар



Хүний эрүүл мэнд халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 35.2, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах гэмт хэрэг 37.0, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 63.6, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 50.9, дээрэм 60.0, залилах гэмт хэрэг 66.7, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг 75.0 хувиар тус тус буурч, тээврийн хэрэгслийн ашиглалт ХАБ-ын эсрэг гэмт хэрэг 2 дахин өсчээ.

Гэмт хэргийг үйлдэгдсэн байдлаар нь авч үзвэл гэр бүлийн хүчирхийллийн улмаас 6, согтуугаар үйлдэгдсэн 60, гудамж талбайд 23, гэр орон сууцанд 51, бүлэглэн үйлдсэн 18 гэмт хэрэг бүртгэгджээ.

Зураг 12.2 Гэмт хэргийн гаралт, төрлөөр, тоо




Гэмт хэрэг үйлдсэн хүний тоо 136 болж, өмнөх оноос 33 хүнээр буурсан байна. Гэмт хэрэг үйлдэгдсэн байдлаар авч үзвэл эмэгтэй хүн оролцсон 12 хэрэг, хүүхэд оролцсон 7 хэрэг гарсан байна.

Гэмт хэргийн улмаас 349.3 сая төгрөгийн хохирол учраад байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 62.1 (15.1%) сая төгрөгөөр өсч, иргэд байгууллагад учруулсан нийт хохирлын 205.6 сая

төгрөг буюу 58.9 хувийг нөхөн төлүүлжээ. Хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын үед 99.1 сая төгрөгийн хөрөнгө битүүмжилсэн байна.

Зураг 12.3 Хохирол, нөхөн төлөлт сая.төгрөг




Энэ оны эхний 9 сард бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх нь Улаангом суманд үйлдэгдсэн бөгөөд нийт 57 тохиолдол гарч, өнгөрсөн оны мөн үеэс 81 гэмт хэргээр буурсан байна.

Аймгийн хэмжээнд нийт 12858 зөрчил шийдвэрлэсэн нь өнгөрсөн оноос 1595 (14.2%) зөрчлөөр өссөн байна. 425 хүн тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулж торгуулжээ.

12.2 Шүүхийн статистик


Аймгийн шүүхийн тамгын газраас ирүүлсэн мэдээллээр, энэ оны 9 сард шүүхээр нийт 898 хэрэг шийдвэрлэжээ. Шүүхийн төрлөөр авч үзвэл эрүүгийн хэрэг 148, иргэний хэрэг 662, давж заалдах шатны шүүхээр 73, захиргааны 15 хэрэг тус тус шийдвэрлэсэн байна.

Зураг 12.4 Шүүхээр шийдвэрлэсэн гэмт хэргийн тоо, шүүхийн төрлөөр



Шүүхээр ял шийтгүүлсэн нийт 195 иргэн үүнээс хорих ял шийтгүүлсэн 60 иргэн байна.

Зураг 12.5 Ял шийтгүүлсэн хүний тоо, насны бүлгээр



Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

Гэмт хэргийн хохирогч: МУ-ын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд,бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгэдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол:МУ-ын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: МУ-ын "Эрүүгийн хянан шийдвэрлэх тухай" хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.




XIV. МӨНГӨ, БАНК

Монгол банкны мэдээгээр зээлийн өрийн үлдэгдэл 170.2 тэрбум төгрөг, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 2.6 тэрбум төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 25.5 (13.0 %) тэрбум төгрөгөөр буурч, хугацаа хэтэрсэн зээл 69.1 (2.8%) сая төгрөгөөр өсчээ.


7.1 тэрбум төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.2 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 4.1 (36.4 %) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 14.1 Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл, тэрбум төгрөг



Нийт хадгаламжийн үлдэгдэл 153.7 тэрбум төгрөг болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 37.4 (32.2 %) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 14.2 Нийт хадгаламжийн үлдэгдэл, тэрбум төгрөг



Нийт хадгаламжийн үлдэгдлийн 73.0 хувь нь хугацаатай, 27.0 хувь нь хугацаагүй хадгаламж байна. Хадгаламж эзэмшигчдийн тоо давхардсан тоогоор 78.3 мянгад хүрчээ.




XV. ТӨРИЙН САНХҮҮ

15.1 ОРОН НУТГИЙН ТЭСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор энэ оны эхний 9 сард аймгийн төсөвт 29.0 тэрбум төгрөг оруулахаас 29.5 тэрбум төгрөгийн орлого орж төлөвлөгөөг 0.5 (1.7%) тэрбум төгрөгөөр давуулан биелүүллээ.


Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 11.6 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 12.5 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 0.9 (8.4%) тэрбум төгрөгөөр давуулан биелүүллээ. Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 4156.5 сая төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 4625.9 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 469.4 (11.3%) сая, аймгийн төсөвт өөрийн орлогоор 7403.4 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 7908.6 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 505 (6.8%) сая төгрөгөөр давуулан биелүүллээ. Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймгийн төвлөрүүлсэн нийт орлого 493.0 (4.1%) сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлсэн орлого 918.6 (13.1%) сая төгрөгөөр нэмэгдэж, улсын төсөвт төвлөрүүлсэн орлого 425.6 (8.4%) сая төгрөгөөр буурсан байна.

Зураг 15.1 Төсвийн орлогын бүтэц, хувиар



Оны эхний 9 сард улсын төсөвт төвлөрүүлэх орлогуудаас нэмэгдсэн өртгийн татвар 440.9 (12.5%) сая төгрөгөөр, аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар 106.3 (42.5%) сая төгрөгөөр, онцгой албан татвар 20.1 (14.3 %), агаарын бохирдлын төлбөр 4.0 (5.4%) сая төгрөгөөр тус тус давж биелэгдсэн бол, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 101.8 (65.9%) сая төгрөгөөр тус тус тасарсан байна.


Зураг 15.2 Төсвийн орлогын өсөлт бууралт, онуудаар, сая төгрөг



Аймгийн нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 26.5 хувиар өссөн байна.

Аймгийн төсвийн зарлагад өөрөө бүрдүүлсэн орлогын эзлэх хувь 18.1 байгаа нь өмнөх оны мөн үеэс 7.2 пунктээр буурсан байна.


Зураг 15.3 Аймгийн төсвийн зарлагад өөрөө бүрдүүлсэн орлогын эзлэх хувь



15.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА


Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 69.3 тэрбум төгрөгийн зардал гаргасан нь өнгөрсөн оны мөн үеэс 37.0 хувиар өсчээ.

Зураг 15.4 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөг



Төсвийн зарлагын 48.0 хувийг цалин, 6.0 хувийг НДШ, 17.6 хувийг урсгал шилжүүлэг, 18.4 хувийг хөрөнгө оруулалт, 10.0 хувийг бусад зарлага эзэлж байна.

Зураг 15.5 Төсвийн зарлагын бүтэц, хувь




15.3 ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА


Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр энэ оны эхний 9 сард 159.6 сая төгрөгийн өртэй, 57.7 сая төгрөгийн авлагатай гарсан байна.

Зураг 15.6 Төсөвт байгууллагуудын өглөг, авлага

Төсөвт байгууллагуудын өглөг жил бүрийн 9 сарын эцэст, сая.төгрөг



Төсөвт байгууллагуудын авлага жил бүрийн 9 сарын эцэст, сая.төгрөг



Ойлголт тодорхойлолт:

Тэнцвэржүүлсэн орлого: Татварын болон татварын бус орлогоос Орон нутгийн төсөв: Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлан аймаг,нийслэл,сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж, зарцуулах төсөв.

Татварын орлого: Орлогын албан татвар, нийгмийн даатгалын орлого, хөрөнгийн албан татвар, нэмэгдэл өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын орлого, гадаад үйл ажиллагааны орлого, бусад татвар, төлбөр хураамжаас бүрдэнэ.

Татварын бус орлого: Нийтлэг татварын бус орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлого, улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээс бүрдэнэ

Төсвийн орлого: Ирээдүйн өв сан,тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.


Урсгал зардал: Бараа,ажил үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс бүрдэнэ.



XVI. ГАДААД ХУДАЛДАА

Энэ оны 9 сарын байдлаар импорт 14466.0 мянган америк долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1827.6 (12.2 %) мянган америк доллараар буурсан байна. Гол нэрээс дурдвал цахилгаан 94106.0 мянган киловатт цаг, авто бензин 8487.8 тонн, дизель түлш 11179.2 тонн, хивэг 4373.3 тонн, овъёос 2646.7 тонн, мебель тавилга 117 ширхэг, банз мод 456.1 м3 тус тус импортоор оруулсан байна.

Зураг 16.1 Нийт импорт,экспорт жил бүрийн эхний 9 сараар мян.ам.доллар



Энэ оны эхний 9 сарын байдлаар нийт экспорт 536.9 мянган америк долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 447.2 (5.9 дахин) мянган америк доллараар өссөн байна. Гол нэрийг дурдвал гоймон 0.4 тонн , цай 0.9 тн , хивс 1013.8 м2, нүүрс 0.2 тонн, хонины мах 98.0 тонн, ямааны мах 19.0 тонныг тус тус экспортлосон байна.

Ойлголт тодорхойлолт:

Гадаад худалдааны барааны эргэлт: Экспорт,импортын нийлбэрээр тодорхойлно.

Импорт: Улсын материаллаг нөөцийг нэмэгдүүлэн,хилийн чанадаас эдийн засгийн нутаг дэвсгэрт оруулж байгаа барааг тооцно. Нийт импортод гадаадын барааны шууд импорт, дотоодын барааны реимпорт багтана.


Экспорт: Улсын материаллаг нөөцийг хорогдуулан, эдинй засгийн нутаг дэвсгэрээс хилийн чанадад гаргаж байгаа барааг тооцно. Нийт экспортод дотоодын барааны шууд экспорт, гадаадын барааны реэкспорт багтана.



XVII. ҮНЭ
17.1 Хэрэглээний үнэ

Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлэг, сагсны 238 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж сарын инфляци тооцож байдаг. Энэ оны 9-р сарын 15-21 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын ерөнхий индекс өнгөрсөн оны мөн үеэс 2.7 хувь, өмнөх оны эцсээс 1.8 хувиар, өмнөх сараас 0.7 хувиар тус тус өссөн байна.

Зураг 17.1 Үнийн өөрчлөлт бүлгээр




Өмнөх сараас хүнсний бараа, тээврийн бүлгийн үнэ 0.8 хувиар буурч, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 0.8, түлш цахилгааны бүлгийн үнэ 0.4, амралт чөлөөт цаг соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ 1.0, хувцас бөс барааны бүлгийн үнэ 1.3, зочид буудал нийтийн хоолны бүлгийн үнэ 0.1, гэр ахуйн тавилгын бүлгийн үнэ 1.7, бусад бүлгийн үнэ 1.6 хувиар тус тус өсч, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ тогтвортой байсан байна.

Зураг 17.2. Сүүлийн 4 жилийн индексийг өмнөх сар, оны эхтэй харьцуулсан индекс



Сүүлийн 4 жилийн 9-р сарыг: өмнөх оны эхтэй харьцуулсан индексээс харахад хамгийн өндөр нь 2019 оны 8-р сард 6.5 хувь, хамгийн бага нь 2020 оны 9-р сард 1.8 хувь өсч, өмнөх сартай харьцуулсан индексээс харахад хамгийн өндөр нь 2020 оны 9 сард 0.7 хувиар өсч, хамгийн бага нь 2017, 2018 оны 9-р сард 0.5 хувиар буурч байсан үзүүлэлттэй тооцогдож байна.

Зураг 17.3. Сарын инфляцийн түвшин




Өргөн хэрэглээний 11 бараа, бүтээгдэхүүний үнийг 7 хоног бүрийн 3 дахь өдөр цуглуулж өөрчлөлтийг судалж байна.


Махны дундаж үнэ:

2020 оны 9-р сард хонины махны дундаж үнэ сарын 2 дахь долоо хоногт 500 төгрөгөөр буурсан бол үхрийн махны дундаж үнэ сарын сүүлийн долоо хоногоос 500 төгрөгөөр буурч сарын турш тогтвортой байлаа. Ямааны махны дундаж үнэ сарын 2 дахь долоо хоногоос 1000 төгрөгөөр нэмэгдэж сарын сүүлч хүртэл тогтвортой байлаа.

Зураг 17.4. Махны үнэ, долоо хоногоор, төрлөөр



9-р сард дунджаар 1 кг хонины мах 8250, үхрийн мах 8375, ямааны мах 6500, 1 л шингэн сүү 1100 төгрөг, элсэн чихэр 2417 төгрөг, цагаан будаа 2575 төгрөг, бензин А-80 1503, А-92 1596, дизель түлш 1950 төгрөгийн дундаж үнэтэй байсан байна.






17.2 Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2020 оны 9 дүгээр сард атан тэмээ 1.1 сая төгрөг, соёолон үрээ 843.0 мянган төгрөг, хязаалан гуна 708.0 мянган төгрөг, эр хонь 180.0 мянган төгрөг, эр ямаа 114.0 мянган төгрөг байна.

Зураг 1. Нас гүйцсэн малын дундаж үнэ, жил бүрийн 9 дүгээр сард, мянган төгрөг



9 сард эр хонь Давст, Малчин, Өндөрхангай суманд хамгийн их буюу 200.0 мянган төгрөг, Өмнөговь, Ховд суманд хамгийн бага буюу 150.0 мянган төгрөг байна.

Зураг 2. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ, 2020 оны 9 дүгээр сард, мянган төгрөгөөр



Ойлголт тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа үйлчилгээний нэр төрлийг жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийг хэлнэ.

Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна. ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно.

$$I_p^t = \frac{\sum_{i=1}^n (p_t^i * q_0^i)}{\sum_{i=1}^n (p_0^i * q_0^i)}$$

- I_p^t - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс
- t – Тайлант үе
- 0 – Суурь үе
- p_t^i – i барааны тайлант үеийн үнэ
- p_0^i – i барааны суурь үеийн үнэ
- q_0^i - i барааны суурь үеийн худалдан авсан тоо

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа үйлчилгээний сагсыг аймагт 238 нэрийн бараа үйлчилгээгээр бүрдүүлж, Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 сараас эхлэн тархааж байна.ХҮИ-ийг тооцоходоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан.Мөн аймгийн дундаж үнийг тооцоходоо сонгогдсон 7 сумын үнийн мэдээллийг хамруулдаг.

Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, аймгийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.




XVIII. ХӨДӨӨ АЖ АХУЙ

18.1 Төллөлт, төл бойжилт

Аймгийн хэмжээнд төллөх насны нийт 1.5 сая хээлтэгч малын 1292.1 мянга нь энэ оны эхний 9 сард төллөсөн байна. Эм хонины 90.2 хувь, эм ямааны 89.2 хувь, ингэний 42.0 хувь, үнээний 75.7 хувь, гүүний 74.6 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 98.3 хувь буюу 1270.5 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 247.0 (24.1 %) мянгаар өссөн байна.


Зураг 18.1 ТӨЛЛӨЛСӨН ЭХ БА БОЙЖИЖ БУЙ ТӨЛ, мянган толгой



18.2 Том малын зүй бусын хорогдол

Том малын зүй бус хорогдол 2020 оны эхний 9 сард аймгийн хэмжээнд 14.0 мянга болж, өмнөх оны мөн үеэс 110.1 (8.8 дахин) мянгаар буурчээ. Том малын зүй бус хорогдлыг төрлөөр нь авч үзвэл хонь 6.5 мянга, ямаа 6.0 мянга, үхэр 0.9 мянга, адуу 0.6 мянга, тэмээ 40-өөр хорогдсон байна. Нийт хорогдсон малын 42.6 хувийг ямаа, 46.7 хувийг хонь эзэлж байна. Аймгийн хэмжээнд өвчнөөр хорогдсон мал 0.3 мянга болж, өмнөх оны мөн үеэс 1.2 (4.8 дахин) мянгаар буурчээ.

Зураг 18.2 ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ, мянган толгой




18.3 Үр тариа, төмс хүнсний ногоо тариалалт


Ургац хураалтын явцын мэдээгээр 2853.0 тонн үр тариа, үүнээс 2325.0 тонн улаан буудай, 1832.8 тонн төмс, 1874.4 тонн хүнсний ногоо, 6724.0 тонн тэжээлийн ургамал, 29.6 мянган тонн байгалийн хадлан бэлтгэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үр тариа 1187.0 тонн, байгалийн хадлан 4278.6 тонн, хүнсний ногоо 108.6 тонноор бага, тэжээлийн ургамал 58.0 тонн, төмс 61.1 тонноор их байна.

Баруунтуруун сум 1625 тонн, Тариалан сум 1152.0 тонн үр тариа хураасан нь аймгийн нийт хураасан үр тарианы 97.3 хувийг эзэлж байна. Улаангом сум 2914.9 тонн төмс, хүнсний ногоо хураасан нь аймгийн нийт төмс, хүнсний ногооны 78.6 хувийг эзэлж байна.

Зураг 18.3 ХУРААСАН ҮР ТАРИА, тонноор, жил бүрийн 9 сарын байдлаар



Зураг 18.4 ХУРААСАН УРГАЦ, тонноор, жил бүрийн 9 сарын байдлаар



Ойлголт тодорхойлолт:

Том малын зүй бусын хорогдол. Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон /халдвартай, халдваргүй/, зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсог төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-аар үржүүлж тооцно.

Бэлэн хээлтэгч. Малыг төрөл бүр дэх нас гүйцсэн эм малыг хамруулна.


Тариалсан талбай. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг өрх, аж ахуйн нэгж байгууллагын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг хэлэх бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.



XIX АЖ ҮЙЛДВЭР

Аж үйлдвэрийн салбарын аж ахуйн нэгжүүд оны эхний 9 сард оны үнээр 10.3 тэрбум төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэж 13.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь өнгөрсөн оны мөн үеэс үйлдвэрлэлт 0.9 хувиар, бүтээгдэхүүний борлуулалт 34.0 хувиар тус тус өссөн байна.

Зураг 19.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, борлуулалт, оны үнээр, тэрбум төгрөгөөр




Зураг 19.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт салбараар, оны үнээр, тэрбум төгрөгөөр



Нийт үйлдвэрлэлтийн 53.2 хувийг дулаан түгээлт усан хангамж, 42.6 хувийг боловсруулах салбарын үйлдвэрлэл, 4.2 хувийг уул уурхайн олборлолт эзэлж байна.

Зураг 19.2 Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийн салбарын бүтэц, хувь



Өнгөрсөн оны мөн үеэс дулаан, усан хангамжийн үйлдвэрлэлт 8.0 хувиар өсч, боловсруулах үйлдвэрийн үйлдвэрлэлт 4.3 , уул уурхайн олборлолт 20.4 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын ажиллагсдын тоо 851 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 16.1 хувиар өссөн байна.

Энэ оны эхний 9 сард аж ахуйн нэгжүүд 100 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 34 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд өсөлт гарч үүнээс өмнөх оны мөн үед үйлдвэрлэгдэж байгаагүй 24 нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн байна.

Ойлголт тодорхойлолт:

Эдийн засгийн үйл ажиллагааны ангилал: НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд нийцүүлэн боловсруулсан үндэсний ангилал юм.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.


Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.



ХХ ТЭЭВЭР

2020 оны 3 дугаар улиралд зорчигч тээврийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэд 57.5 мянган зорчигч тээвэрлэж 79617.4 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийснийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зорчигчдын тоо 35.6 хувиар, зорчигч эргэлт нь 90.0 хувиар өссөн байна. Ачаа тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд 5.0* мян.тн ачаа тээвэрлэж 1195.2* мян.тн.км-ийн ачаа эргэлт хийжээ.

Зураг 20.1 Тээсэн ачаа, зорчигчдын тоо



*Аймгийн АТТ-д орон нутгийн постуудаар гарсан ачааг бүртгэх нэгдсэн систем байхгүй учир зөвхөн ачаа тээвэрлэсэн ААНБ-ын мэдээг оруулсан болно.

Ойлголт тодорхойлолт:

Ачаа эргэлт.Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тонн километрээр илэрхийлнэ.

Зорчигч эргэлт. Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.

Бүлэг. Бусад

1.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ ийн үйлчилгээний мэдээлэл

Улаангом сумын “ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ” үйлчилгээнийхээ хүрээг 96 болгон өргөтгөн нэмж нийт 32246 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Энэ оны 3-р улиралд нийгмийн даатгалын үйлчилгээгээр 1254, төрийн банкны үйлчилгээгээр 10750 , хөдөлмөр халамж үйлчилгээний газрын үйлчилгээгээр 4020 , улсын бүртгэлийн үйлчилгээгээр 3615, цахилгаан, дулаан, усны холбоотой үйлчилгээгээр 6455 иргэн үйлчлүүлсэн байна.

Хүснэгт 1.Үйлчилгээний төрлийн тоо, байгууллагаар

| № | Үйлчилгээ үзүүлэх байгууллагын нэр | Үзүүлж буй үйлчилгээний нэр төрлийн тоо | Үйлчилгээ авсан иргэдийн тоо |
|----|------------------------------------|---|------------------------------|
| 1 | үйлчилгээний нэгдсэн төвийн алба | 77 | 931 |
| 2 | Чандман Увс ххк | 6 | 1380 |
| 3 | Дулааны 2-р станц | 5 | 1300 |
| 4 | Хур систем / | 10 | 580 |
| 5 | Гадаадын иргэн харьяатын газар | 10 | 25 |
| 6 | Улаангом сумын 3-р баг | 12 | 1145 |
| 7 | Улсын бүртгэлийн хэлтэс | 13 | 3615 |
| 8 | цахилгаан түгээх сүлжээ | 2 | 3775 |
| 9 | Хөдөлмөр халамж үйлчилгээний газар | 19 | 4020 |
| 10 | татварын хэлтэс | 5 | 658 |
| 11 | Төрийн банк | 14 | 10750 |
| 12 | Түншлэл танхим | 12 | 98 |
| 13 | Таны танхим | 7 | 125 |
| 14 | Юнител | 4 | 818 |
| 15 | эрчим хүчний зохицуулах зөвлөл | 4 | 47 |
| 16 | Хууль зүйн туслалцааны төв | 4 | 201 |
| 17 | Компьютер, канон зурагчин | 12 | 1244 |
| 18 | Гэрэгэ киоск | 108 | 280 |
| 19 | нийгмийн даатгалын хэлтэс | 6 | 1254 |
| | Нийт дүн | 96 | 32246 |

Зураг 1 Үйлчлүүлсэн иргэдийн тоо, байгууллагаар



УВС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

П.ТУНГАЛАГ



2020 оны 10 дугаар сарын 12

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2020 оны эхний 9 сард

| ҮЗҮҮЛЭЛТҮҮД | ХЭМЖИХ НЭГЖ | 2017 I-IX | 2018 I-IX | 2019 I-IX | 2020 I-IX |
|--|----------------|---------------------------|---------------------------|----------------------------|---------------------------|
| Төрсөн хүүхдийн тоо | амьд төрөлт | ▲ 1546 ^{-1.0} | ▼ 1382 ^{-10.6} | ▼ 1444 ^{4.5} | ▲ 1543 ^{6.9} |
| Нас баралт | тоо | ▼ 316 ^{-11.2} | ▲ 351 ^{11.1} | ▼ 337 ^{-4.0} | ▼ 325 ^{-3.6} |
| 0- 5 насны хүүхдийн эндэгдэл | тоо | ▼ 32 ^{-30.4} | ▼ 31 ^{-3.1} | ▼ 27 ^{-12.9} | ▼ 24 ^{-11.1} |
| 0-1 насны хүүхдийн эндэгдэл | тоо | ▼ 26 ^{-35.0} | ▼ 24 ^{-7.7} | ▼ 19 ^{-20.8} | ▲ 21 ^{10.5} |
| Халдварт өвчний гаралт | тоо | ▼ 476 ^{-20.5} | ▲ 499 ^{4.8} | ▼ 389 ^{-22.0} | ▲ 430 ^{10.5} |
| 10000 хүнд ноогдох халдварт өвчин | тоо | ▼ 58.5 ^{-21.5} | ▲ 60 ^{2.6} | ▼ 47 ^{-21.7} | ▲ 52 ^{10.6} |
| Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо | тоо | ▲ 265 ^{11.8} | ▼ 242 ^{-8.7} | ▼ 254 ^{5.0} | ▼ 147 ^{-42.1} |
| Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо,сарын эцэст | хүн | ▼ 877 ^{-0.8} | ▼ 704 ^{-19.7} | ▲ 714 ^{1.4} | ▲ 729 ^{2.1} |
| үүнээс эмэгтэй | хүн | ▼ 457 ^{-16.5} | ▼ 375 ^{-17.9} | ▲ 387 ^{3.2} | ▼ 383 ^{-1.0} |
| Нийгмийн даатгалын сангийн орлого | сая.төг | ▲ 11392.3 ^{12.7} | ▲ 11752.2 ^{3.2} | ▲ 15261.8 ^{29.9} | ▲ 15583.2 ^{2.1} |
| Нийгмийн даатгалын сангийн зарлага | сая.төг | ▲ 31082.6 ^{7.0} | ▲ 35657.8 ^{14.7} | ▲ 42997.3 ^{20.6} | ▲ 48321.6 ^{12.4} |
| Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ | сая.төг | ▲ 26446.5 ^{6.0} | ▲ 30406.2 ^{15.0} | ▲ 34776.9 ^{14.4} | ▲ 41110.6 ^{18.2} |
| Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ | сая.төг | ▲ 7357.0 ^{6.4} | ▲ 10901.3 ^{48.2} | ▼ 10199.7 ^{-6.4} | ▲ 10440.2 ^{2.4} |
| Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан хүн | хүн | ▼ 31401 ^{-0.1} | ▲ 41430 ^{31.9} | ▼ 33400 ^{-19.4} | ▲ 36050 ^{7.9} |
| Аймгийн төсвийн орлого,оны үнээр | сая.төг | ▲ 7665.7 ^{9.3} | ▲ 8968.5 ^{17.0} | ▲ 12041.5 ^{34.3} | ▲ 12534.5 ^{4.1} |
| Төсвийн зарлага,оны үнээр | сая.төг | ▼ 42784.0 ^{-0.9} | ▲ 47563.8 ^{11.2} | ▲ 50544.4 ^{6.3} | ▲ 59250.5 ^{17.2} |
| Төсвийн өглөг | сая.төг | ▼ 569.3 ^{-32.9} | ▼ 350.1 ^{-38.5} | ▲ 476.8 ^{36.2} | ▼ 159.6 ^{-66.5} |
| Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны эцэстэй харьцуулсан) | хувь | ▲ 4.7 | ▲ 3.8 | ▲ 6.5 | ▲ 1.8 |
| Хэрэглээний үнийн индекс (өмнөх сартай харьцуулсан) | хувь | ▼ -0.5 | ▼ -0.5 | ▲ 0.0 | ▲ 0.7 |
| Хэрэглээний үнийн индекс (өмнөх оны мөн үетэй харьцуулсан) | хувь | ▲ 6.1 | ▲ 8.1 | ▲ 9.3 | ▲ 2.7 |
| Банкны зээлийн үлдэгдэл | тэрбум.төг | ▲ 174.3 ^{4.7} | ▲ 187.6 ^{7.6} | ▲ 195.7 ^{4.3} | ▼ 170.2 ^{-13.0} |
| Үүнээс: хугацаа хэтэрсэн | тэрбум.төг | ▼ 6.3 ^{-3.1} | ▼ 2.6 ^{-58.7} | ▼ 2.5 ^{-3.8} | ▲ 2.6 ^{4.0} |
| Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл оны үнээр | сая.төг | ▲ 6594.7 ^{7.7} | ▲ 10606.4 ^{60.8} | ▼ 10155.6 ^{-4.3} | ▲ 10251.5 ^{0.9} |
| Үүнээс: Уул уурхай олборлох үйлдвэр | сая.төг | ▲ 608.6 ^{20.8} | ▼ 565.8 ^{-7.0} | ▼ 545.0 ^{-3.7} | ▼ 434.0 ^{-20.4} |
| Боловсруулах аж үйлдвэр | сая.төг | ▲ 2859.8 ^{20.0} | ▲ 4923.0 ^{72.1} | ▼ 4564.9 ^{-7.3} | ▼ 4368.3 ^{-4.3} |
| дулаан түгээлт, усан хангамж | сая.төг | ▼ 3126.3 ^{-3.5} | ▲ 5117.8 ^{63.7} | ▼ 5045.7 ^{-1.4} | ▲ 5449.2 ^{8.0} |
| Аж үйлдвэрийн борлуулалт, оны үнээр | сая.төг | ▲ 7182.8 ^{31.4} | ▲ 11882.3 ^{65.4} | ▼ 10003.6 ^{-15.8} | ▲ 13429.7 ^{34.2} |
| Том малын хорогдол бүгд | мян.тол | ▼ 19.8 ^{-88.9} | ▲ 100.9 ^{409.6} | ▲ 124.1 ^{23.0} | ▼ 14.0 ^{-88.7} |
| Төллөсөн эх | мян.тол | ▲ 1101.8 ^{26.4} | ▼ 1079.0 ^{-2.1} | ▲ 1096.0 ^{1.6} | ▲ 1292.1 ^{17.9} |
| Бойжсон төл | мян.тол | ▲ 1084.8 ^{39.7} | ▼ 969.3 ^{-10.6} | ▲ 1023.5 ^{5.6} | ▲ 1270.5 ^{24.1} |
| Тариалсан талбай | га | ▲ 9783.3 ^{71.1} | ▲ 15120.9 ^{54.6} | ▲ 20307.1 ^{34.3} | ▲ 28052 ^{38.1} |
| Хураасан ургац тн | тн | ▲ 12813.6 ^{20.9} | ▼ 9778.5 ^{-23.7} | ▼ 7794.7 ^{-20.3} | ▼ 6560.2 ^{-15.8} |
| үр тариа | тн | ▲ 7748.4 ^{60.8} | ▼ 6241.5 ^{-19.4} | ▼ 4040.0 ^{-35.3} | ▼ 2853 ^{-29.4} |
| төмс | тн | ▼ 2389.9 ^{-19.1} | ▼ 1714.6 ^{-28.3} | ▲ 1771.7 ^{3.3} | ▲ 1832.8 ^{3.4} |
| хүнсний ногоо | тн | ▼ 2675.3 ^{-5.3} | ▼ 1822.4 ^{-31.9} | ▲ 1983.0 ^{8.8} | ▼ 1874.4 ^{-5.5} |

▲ Эерэг өөрчлөлт
▼ Сөрөг өөрчлөлт

Сумдын эдийн засаг нийгмийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд, 2020 оны эхний 9 сар

| сумдын нэр | бойжсон төл | том малын зүй бус хорогдол | Гарсан гэмт хэрэг бүгд | НДС-ийн | |
|------------------|---------------|----------------------------|------------------------|----------------|--------------|
| | | | | орлого* | ТБ % |
| хэмжих нэгж | мян.тол | мян.тол | тоо | сая.төг | хувь |
| ДҮН | 1270.5 | 14.0 | 147 | 13457.3 | 140.4 |
| Баруунтуруун | 29.7 | 0.5 | 3 | 514.7 | 144.1 |
| Бөхмөрөн | 56.2 | 0.2 | | 248.9 | 152.3 |
| Давст | 38.5 | 1.3 | 4 | 203.3 | 151.7 |
| Завхан | 39.9 | 0.2 | 5 | 212.0 | 152.8 |
| Зүүнговь | 55.7 | 0.4 | 0 | 347.1 | 165.1 |
| Зүүнхангай | 72.1 | 0.3 | 5 | 283.3 | 151.3 |
| Малчин | 66.6 | 1.4 | 5 | 268.2 | 143.4 |
| Наранбулаг | 89.6 | 0.2 | 6 | 342.5 | 152.6 |
| Өлгий | 57.6 | 0.2 | 3 | 274.6 | 152.4 |
| Өмнөговь | 84.1 | 0.6 | 8 | 426.3 | 151.9 |
| Өндөрхангай | 83.8 | 1.6 | 6 | 368.3 | 153.3 |
| Сагил | 77.5 | 0.1 | 7 | 257.5 | 172.2 |
| Тариалан | 64.6 | 0.4 | 4 | 405.6 | 137.5 |
| Түргэн | 58.8 | 0.6 | 3 | 210.8 | 152.1 |
| Тэс | 94.3 | 3.4 | 13 | 510.0 | 157.3 |
| Ховд | 66.5 | 0.4 | 7 | 307.5 | 166.1 |
| Хяргас | 80.9 | 0.4 | 1 | 301.1 | 152.2 |
| Цагаанхайрхан | 64.4 | 1.6 | 10 | 264.1 | 158.9 |
| Улаангом | 89.8 | 0.4 | 57 | 7711.5 | 132.5 |
| 2020 I-IX | 1023.5 | 124.1 | 254 | 11908.4 | 117.7 |

*ЭМД-ын сангийн орлого ороогүй дүн

Сумдын эдийн засаг нийгмийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд, / үргэлжлэл /
(сумдаар)

| сумдын нэр | Халдварт өвчний гаралт | 10000 хүн амд | Нялхсын эндэгдэл | Амьд төрсөн 1000 хүүхдэд | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл | 1000 амьд төрөлтөд | Осол гэмтлийн өвчлөл, хүн | хүн амын нас баралт |
|------------------|------------------------|---------------|------------------|--------------------------|-----------------------------------|--------------------|---------------------------|---------------------|
| хэмжих нэгж | тоо | тоо | хүн | хүн | хүн | хүн | хүн | хүн |
| ДҮН | 430 | 52 | 21 | 13.6 | 24 | 15.6 | 601 | 325 |
| Баруунтуруун | 8 | 30.1 | 2 | 77 | 2 | 76.9 | 33 | 10 |
| Бөхмөрөн | 3 | 13.3 | | | | | 13 | 6 |
| Давст | 6 | 37.2 | | | | | | 3 |
| Завхан | 2 | 10.8 | | | | | 14 | 6 |
| Зүүнговь | 10 | 35.6 | 1 | 71 | 1 | 71.4 | 45 | 9 |
| Зүүнхангай | 5 | 21.4 | | | | | 9 | 6 |
| Малчин | 5 | 20.4 | | | | | 7 | 12 |
| Наранбулаг | 19 | 44.3 | | | | | 29 | 17 |
| Өлгий | 5 | 20.7 | | | | | 15 | 16 |
| Өмнөговь | 4 | 8.6 | 1 | 22.2 | 1 | 22.2 | 31 | 17 |
| Өндөрхангай | 15 | 46.7 | 1 | 47.6 | 1 | 47.6 | 29 | 8 |
| Сагил | 0 | 0.0 | 1 | 250.0 | 1 | 250.0 | 7 | 3 |
| Тариалан | 15 | 37.8 | | | 1 | 25.6 | 8 | 18 |
| Түргэн | 9 | 43.1 | | | | | 9 | 7 |
| Тэс | 13 | 25.4 | | | | | 19 | 15 |
| Ховд | 5 | 20.3 | | | | | | 7 |
| Хяргас | 4 | 15.7 | 1 | 250.0 | 1 | 250.0 | 3 | 13 |
| Цагаанхайрхан | 4 | 19.4 | | | 1 | 500.0 | | 8 |
| Улаангом | 298 | 94.0 | 14 | 10.6 | 15 | 10.6 | 330 | 144 |
| 2019 I-IX | 389 | 47.0 | 19 | 13.2 | 27 | 18.7 | 471 | 337 |

Бүлэг 4. Хөдөлмөр эрхлэлт

БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙЧҮҮДИЙН ТОО, 2020 оны 9 сарын байдлаар

| үзүүлэлт | 2017 I-IX | | 2018 I-IX | | 2019 I-IX | | 2020 I-IX | | |
|---|-----------|---------|-----------|---------|-----------|---------|-----------|---------|-----|
| | Бүгд | эмэгтэй | Бүгд | эмэгтэй | Бүгд | эмэгтэй | Бүгд | эмэгтэй | |
| Өмнөх сарын эцэст байсан ажилгүйчүүд | 904 | 457 | 637 | 338 | 711 | 384 | 863 | 450 | |
| Тайлант сарын эцэст байгаа ажилгүйчүүд | 877 | 457 | 704 | 375 | 714 | 387 | 729 | 383 | |
| Хөгжлийн бэрхшээлтэй ажилгүйчүүд | 13 | 3 | 26 | 9 | 23 | 13 | 14 | 4 | |
| Насны бүлгээр | 15-24 | 217 | 122 | 113 | 68 | 104 | 62 | 188 | 101 |
| | 25-34 | 325 | 188 | 242 | 138 | 265 | 147 | 353 | 198 |
| | 35-44 | 188 | 93 | 191 | 97 | 201 | 116 | 113 | 56 |
| | 45-54 | 121 | 52 | 138 | 67 | 109 | 53 | 70 | 28 |
| | 55-59 | 23 | 2 | 18 | 5 | 27 | 6 | 4 | 0 |
| | 60+ | 3 | 0 | 2 | 0 | 8 | 3 | 1 | 0 |
| Оны эхэнд байсан ажилгүйчүүд | 981 | 533 | 777 | 386 | 569 | 318 | 493 | 318 | |
| 2020 онд шинээр бүртгүүлсэн ажилгүйчүүд | 2254 | 1154 | 2023 | 1019 | 1915 | 1021 | 2119 | 1126 | |
